

МУИС-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 6 дугаар сарын 11

№ 2020/05

Улаанбаатар хот

Хугацаа: Хурал 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 10:00 цагт эхэлж, 17:30 цагт дуусав.

Байршил: МУИС-ийн хичээлийн I байрны 320 тоот хурлын өрөө

Ирц: Сургалт, оюутан хариуцсан дэд захирал, Хөтөлбөрийн ерөнхий хорооны ахлагч Д.Бадмаанямбуу, Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн дарга, Хөтөлбөрийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Н.Пүрэвцогт, Ахисан түвшний сургуулийн бодлогын газрын дарга Б.Энх-Амгалан, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн захирал Н.Баатарбилэг, Хууль зүйн сургуулийн захирал Ж.Эрдэнэбулган, Шинжлэх ухааны сургуулийн дэд захирал Ц.Амартайван, Шинжлэх ухааны сургуулийн Ази судлалын тэнхимийн эрхлэгч В.Батмаа, Бизнесийн сургуулийн Маркетинг худалдааны тэнхимийн профессор Н.Батнасан, Ерөнхий суурийн хөтөлбөрийн хорооны ахлагч Б.Батжаргал, Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Сайнбилэгт, Эрдмийн зөвлөлийн Сургалтын төрөлжсөн хорооны гишүүн Н.Оюун-Эрдэнэ, П.Мягмарцэрэн, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн захирал С.Баттулга, Эрдэнэт салбар сургуулийн захирал Т.Энх-Амгалан, Шинжлэх ухааны сургуулийн Боловсрол, сэтгэл судлалын тэнхимийн эрхлэгч Б.Хишигням нар оролцов.

Хэлэлцэх асуудал: Тус өдрийн хурлаар нийт 12 асуудал хэлэлцсэнээс Хүрээлэн буй орчин судлал (ХБОС), Байгаль орчныг хамгаалах технологи (БОХТ) хөтөлбөрүүдийг Европын Холбооны санхүүжилттэй INTENSE төслийн хүрээнд сайжруулахдаа баримтлах зарчмыг хэлэлцсэн хэсгийг энэ тэмдэглэлд тусгав.

Асуудлыг танилцуулсан: Тэнхимийн эрхлэгч Ч.Сономдагва, Төслийн удирдагч О.Алтансүх

Хурлын явц:

О.Алтансүх: ХБОС гэдэг хөтөлбөр дэлхийн түвшинд хаашаа чиглэж хөгжиж байна вэ? гэдгийг 2017 оноос МУИС дээр хэрэгжсэн Европын Холбооны ERASMUS төслийн санхүүжилтээр хэрэгжиж буй INTENSE төслийн хүрээнд авч үзсэн байгаа. Төслийн үндсэн зорилго бол Хүрээлэн буй орчны бодлого, менежмент, технологи мэргэжлийн ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг сайжруулах явдал юм. 2016-2019 онд холбогдох гэрээнд тухайн үеийн Сургалт, оюутан хариуцсан дэд захирал, одоогийн реактор болох Б.Очирхуяг захирал гарын үсэг зураад явсан байгаа. Төгсөлтийн дараах хөтөлбөрийг ямар үзэл баримтлалаар шинэчлэх вэ гэдгийг ХЕХ-оор хэлэлцүүлмээр байна. МУИС-ийн бүтцэд тулгуурлаад:

1. Applied science-ийг ХШУИС дотооддоо
2. Environmental management-ийг Бизнесийн сургуультай
3. Environmental police-ийг ХЗС-тай
4. Environmental technology-ийг ХШУИС дотооддоо
5. Environmental economics-ийг ШУС-ийн Эдийн засгийн тэнхимтэй
6. Environmental social assessment- чиглэлийг ШУС-НУС-тай хамран хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Үүнийг хийхдээ олон улсын чиг хандлага, ажил мэргэжлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлана. Бэлтгэл магистрын хөтөлбөрөө 15 багц цагаар гаргасан. Магистрын хөтөлбөрөө мэргэжлийн болон судалгааны гэсэн 2 чиглэлд нь салбар дундын байдлаар явна. Дээрээс нь бэлтгэл докторын хөтөлбөр нэе гэсэн. Тэгээд докторын хөтөлбөр, докторын дараах гэсэн 5 үе шаттайгаар хөтөлбөрөө сайжруулна гэсэн саналтай байна. Түүрүүний хэлсэн 6 чиглэлээр хамтарч хэрэгжүүлэх саналтай байгаа. Эрдэм шинжилгээний багцын хувьд магистр, доктор хоорондоо ижил. Суралцагчдын хувьд сүүлийн 10 жилийн мэдээгээр бакалаврт элссэн 132, төгссөн 91, магистрт элссэн 55, төгссөн 45, докторт элссэн 18, төгссөн 1 байна. Ахисан түвшний хөтөлбөрт элсэгчдийн тоо нь бакалаврын түвшинд элсэгчдийн тооны бараг 50 хувьтай тэнцэж байна. Энэ нь уг хөтөлбөрийн ахисан түвшний сургалт нийгэмд эрэлт хэрэгцээтэй байна гэдгийг харуулж байна. Уг хөтөлбөртэй холбоотой одоогийн байдлаар Хүрээлэн буй орчны лаборатори, Агаар орчин судлалын лаборатори, Байгаль орчны загварчлалын лаборатори гэх 3 лаборатори байна.

Ц.Амартайван: Хими, физик, биологи зэрэг шинжлэх ухааны суурь хичээлүүдээ ШУС-ийн хими, физик, биологийн чиглэлийн хөтөлбөрт тусгагдсан суурь хичээлүүдээс авч тусгах хэрэгтэй.

Д.Бадмаанямбуу: Энэ асуудал дээрээ шийд гаргая. Хүрээлэн буй орчин судлал хөтөлбөрөө ярьсан зарчмынхаа дагуу сайжруулаад ороод ирээрэй.

Шийдвэрлэсэн нь:

ХЕХ-ны гишүүдийн дийлэнх олонхын саналаар ХБОС хөтөлбөрийн шинэчлэл хийх зарчмыг дэмжиж, Хүрээлэн буй орчин судлал хөтөлбөрийн сайжруулсан хувилбарыг дараа хэлэлцэхээр шийдэв.

Хурлын тэмдэглэл хянасан:



Н.Пүрэвцогт (ХЕХ-ны нарийн бичгийн дарга)

Хурлын тэмдэглэл хөтөлсөн

Б.Золзаяа (ХЧБХ-ийн ахлах мэргэжилтэн)